



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар
хийсэн нийцлийн аудитын тайлан*



Булган хот
2018 он

Тайланг бэлтгэсэн:

Булган аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх Аудитор

Д.Анхбаяр

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Ахлах аудитор

Г.Ганбаатар

Ахлах Аудитор

П.Содном

Ахлах Аудитор

Г.Намчинсүрэн

Аудитор

Б.Мөнхтуяа

Аудитор

А.Сувдаа

Аудитор

Д.Даариймаа

Аудитор

З.Ганбаатар

Аудитор

Х.Баттулга

2018 оны 11 дүгээр
сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70342716 дугаарын утас,
70342580

АГУУЛГА

Товчилсон үсгийн жагсаалт.....3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур
үзүүлэлт.....4-5

**Бүлэг А.Төсвийн болон орон нутгийн өмчит хуулийн
этгээдийн 78 хувь хамрагдсан ч байршуулсан нийт
мэдээллийн 87.8 хувь бүртгээгдсэн байна.....5-8**

**Бүлэг Б.Хуулийн 3.1.4-т хамрагдах байгууллагууд
мэдээллийг цахим хуудаст бүртгээгүй байна.....8-9**

**Бүлэг В. Шилэн дансанд бүртгэх мэдээллийн зөрчил
өмнөх оноос 4.5 хувиар өссөн байна.....9-10**

ДҮГНЭЛТ.....10-11

ЗӨВЛӨМЖ.....11-12

ХАВСРАЛТУУД

Байгууллагын санал

Тайлан баталгаажуулсан тушаал

ТОВЧИЛСОН ҮГСИЙНЖАГСААЛТ

YAГ	Үндэсний аудитын газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗД	Аймгийн Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийлээ.

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тави хяналтыг хэрэгжүүлсэн эсэх
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитаар шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд, байгууллагын 70 хувийг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглахын зэрэгцээ хуулийн 3 дугаар зүйл, 8 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуйн нэгж нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллаа.

Аудитад ашиглагдах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой хууль, тогтоол, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль
- ✓ Төрийн аудитын тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Шилэн дансны тухай хууль
- ✓ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- ✓ Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудит хийх бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр, удирдан, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор Г.Ганбаатар, ахлах аудитор Г.Намчинсүрэн, ахлах аудитор П.Содном аудитор П.Мөнхтуяа, А.Сувдаа, Д.Даариймаа, З.Ганбаатар, Х.Баттулга нар 2017 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 32 ажлын хоногт багтаан хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл: Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагууд санхүү, эдийн засгийн бүхий л мэдээллийг байгууллагынхаа цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Энэхүү нийцлийн аудитаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагааг шилэн дансны нэгдсэн мэдээллийн вэб сайт, байгууллагын вэб сайт, байгууллагын мэдээллийн самбарт тавьсан мэдээллийг үзэн шалгаж аудитыг хэрэгжүүллээ.

Аймаг дахь Төрийн аудитын газар

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх?

БүлэгА

Төсвийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 78 хувь хамрагдсан ч байршуулсан нийт мэдээллийн 87.8 хувь бүртгэгдсэн байна.

А.1.Булган аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төрийн өмчит 34 хуулийн этгээд, орон нутгийн өмчит 140 хуулийн этгээд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 16 нийт 190 байгууллага хамрагдахаас 78 хувь буюу төрийн өмчит 24, орон нутгийн өмчит 123, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 3, төрийн өмчит үйлдвэрийн газар 1 нийт 151 байгууллагыг шалгаж үзэхэд Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газруудын нийт мэдээлэл 90.7 хувьтай, шалгасан 151 байгууллагын мэдээлэл 87.8 хувь буюу 3473 мэдээллээс 2823 мэдээллийг байршуулсан байна. /хавсралт1/, /хавсралт2/

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд тус хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг байршуулж хэвшиж байгаа боловч цахим хуудсанд тавигдаж байгаа мэдээлэл нь бүрэн бүтэн, цаг хугацаанд нь мэдээлдэггүй хугацаа хоцроож мэдээлдэг байна.

Мэдээлэл байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хуулийн заалтууд		Мэдээлэл зохиох тоо	Мэдээлсэн	Хугацаа хоцроон мэдээлсэн	Мэдээлээгүй	Хамааралгүй	Мэдээлсэн хувь
6.1.1	Тухайн жилийн төсөв	151	144	5	1	1	96.0
	ОНХС-ийн төлөвлөгөө	151	24	1	0	126	96.0
	ХАА-ны төлөвлөгөө	151	115	8	2	26	92.0
6.1.2	Төсвийн гүйцэтгэл	1812	1677	122	13	0	92.5
	Хагас жилийн төсвийн гүйцэтгэл	151	140	7	4	0	92.7
	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	151	139	3	9	0	92.1
6.1.3	Дараа жилийн төсвийн төсөл	151	119	6	25	1	79.3
6.1.4	Санхүүгийн тайлан /хагас жил/	151	121	13	16	1	80.7
	Санхүүгийн тайлан /жилийн эцсийн/	151	118	1	32	0	78.1
6.1.5	ТЭЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	151	44	2	21	84	65.7
	Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	151	69	6	38	38	61.1
6.1.6	Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	151	113	4	34	0	74.8
НИЙТ		3473	2823	178	195	277	88.3

Дээрх хүснэгтээс дүгнэхэд 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6.1 дэх хэсэгт заасан мэдээллүүдээс 195 мэдээлэл буюу 5.6 хувийг мэдээлээгүй, мөн 178 мэдээлэл буюу 5.1 хувийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Шилэн дансны цахим хуудсанд ил тод болгон мэдээлээгүй 195 мэдээллийг нөхөн байршуулж, илэрсэн зөрчилийг арилгах албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ.

Шилэн дансны хуулийн 3.1.2-д заасан ТӨҮГ, ТӨХК-ууд Булган аймгийн хэмжээнд 7 салбар байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Зам тээврийн хөгжлийн яамны харьяа Нисэх буудал, “Булган АЗЗА” ТӨХК, Автотээвэрийн үндэсний төв, 3 салбар шилэн дансны цахим хуудастай, бусад салбар болох Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Монголын цахилгаан холбоо ТӨХК, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Монгол шуудан ТӨХК зэрэг байгууллагууд харьяалах дээд шатны байгууллагад мэдээллээ нэгтгэн шилэн дансны цахим хуудсанд мэдээлдэг боловч орон нутагт салбартай ТӨҮГ, ТӨХК-ууд шилэн дансны цахим хуудсанд салбар байгууллага тус бүрээр эсвэл нэгтгэж мэдээлэх талаар Шилэн дансны тухай хуулинд тодорхой заагаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар Шилэн дансны тухай хуулийн 6.4-д заасны дагуу 3923 мэдээлэл мэдээлхээс 3145 мэдээллийг мэдээлсэн, 360 мэдээлэл мэдээлээгүй, 53 мэдээлэл хугацаа хоцроосон байгааг хүснэгтээр харуулав.

Долоо хоногийн дотор мэдээллэх мэдээний хүснэгт

№	Хуулийн заалтууд	Мэдээлвэл зохих байгууллагын тоо / гүйлгээний тоо дүн		Мэдээлсэн		Мэдээлээгүй		Хугацаа хоцроосон	Хамааралгүй	Мэдээлсэн хувь
		Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн			
1	6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	151	0	135	0	1	0	15	0	89.4
2	6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	151	0	88	0	1	0	14	48	85.44
3	6.4.3. Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	151	0	83	0	14	0	18	36	72.17
4	6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	422	6628.7	418	6599.5	4	29.2	0	109	95.24
5	6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	346	5573.3	324	5383.8	22	189.5	0	105	82.61
6	6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	460	13506.9	333	11562	127	1944.9	0	97	46.30
7	6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	151	0	0	96	0	0	12	43	89.72
8	6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	151	0	0	130	0	0	9	12	94.20
9	Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл	2091	3765.4	1899	3375.1	192	390.28	0	32	85.71
НИЙТ		3923	29474.3	3145	27146.4	360	2553.9	53	482	82.30

Дээрх хүснэгтээс харахад нийт мэдээлийн 82.3 хувийг мэдээлж нийт гүйлгээний тоогоор авч үзвэл 9.8 хувийг бүртгээгүй, мөнгөн дүнгээр авч үзвэл 7.9 хувийг бүртгээгүй байгаад нөхөж бүртгэхээр холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүллээ.

А.2.Мэдээллийн самбарт мэдээллийг бүрэн гүйцэт мэдээлдэггүй байна.

Байгууллагууд нь шилэн дансны мэдээллийг тус хуулийн 5.1-д өөрийн цахим хуудсаар хүргэж байгаа боловч хуулийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасны дагуу мэдээллийн самбарт байрлуулж байгаа мэдээлэл нь дутуу, мэдээний чанар, стандартыг хангахгүй, зарим мэдээллийг огт мэдээллэхгүй байна. Тухайлбал: Аудитад хамрагдсан байгууллагууд зөвхөн төсөв санхүүгийн ил тодын мэдээллийн самбар дээрээ хуулийн 6.1.2, 6.1.4, 6.1.5 дахь

заалтуудаас бусад мэдээллийг байршуулж хэвшээгүй байгаа нь тус хуулийн 5 дугаар зүйлтэй бүрэн нийцэхгүй байна.

Байгууллага бүр өөрийн бие даасан цахим хуудастай, хэвлэх боломжтой, тодруулга өгөх албан тушаалтны нэр, хаягийг цахим хуудсанд байршуулсан хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан, харин нь ихэнх байгууллагууд мэдээллийн самбар дээр байгууллагын батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ байршуулсан бусад мэдээг тэр бүр байршуулаагүй, аймгийн гамшигаас хамгаалах сан одоо болтол шилэн дансны бие даасан цэс нээлгээгүй, гамшигаас хамгаалах сангийн хөрөнгийг шилэн дансны цахим хуудсаар мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн байна.

Аудитын явцад дээрхи байгууллагуудыг шилэн дансны мэдээллийн самбартай болох, мэдээлэлийг шинэчлэн мэдээлж байх тухай зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймаг дахь Төрийн аудитын газар

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх?

Бүлэг Б

Хуулийн 3.1.4-т хамрагдах байгууллагууд мэдээллийг цахим хуудаст огт бүртгээгүй байна.

Б.1.Булган аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг эзэмшиж байгаа аж ахуй нэгж байгууллага” байхгүй болно.

Б.2.Нийт 37 аж ахуй нэгжээс 27 аж ахуй нэгж байгууллага шилэн дансанд цэс байхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд нийт 42 ажил үйлчилгээг 37 аж ахуй нэгж хийж гүйцэтгэснээс нэг байгууллага буюу “Өвөлжөөн булаг” ХХК 3 ажил үйлчилгээ хийж гүйцэтгэснээс 2 ажил үйлчилгээг бүртгэсэн, 9 аж ахуй нэгжүүд шилэн дансанд цэстэй боловч ямарч мэдээлэл оруулаагүй, 27 байгууллага шилэн дансанд цэс байхгүй байгаад албан шаардлага хүргүүлээ./хавсралт4/

Б.3.Хуулийн 3.1.5-т хамаарах байгууллагуудын 60 хувь нь шилэн дансанд цэсгүй байна.

Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т хамаарах төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчдийн мэдээлэл байршуулсан байдлыг шалгаж үзэхэд нийт 91 иргэн, аж ахуй нэгжүүдээс 55 иргэн, аж ахуй нэгж шилэн дансны цэсгүй буюу 2754.3 сая төгрөгийг бүртгээгүй, 5-н байгууллага 250.7 сая төгрөгийн мэдээллийг бүртгээгүй, 31 байгууллага 1641.3 сая

төгрөгийн мэдээллийг бүртгэсэн байна. Нийт байгууллагын 60 хувь шилэн дансанд цэс байхгүй, 34 хувь нь мэдээлсэн, 6 хувь нь мэдээллээгүй байгаад албан шаардлага хүргүүлээ. /Хавсралт5/

**Аймаг дахь Төрийн
аудитын газар**

Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага албан тушаалтан хянадтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх?

**Шилэн дансанд бүртгэх мэдээллийн зөрчил өмнөх оноос 4.5
Бүлэг В хувиар өссөн байна.**

В.1. Шилэнэн дансны тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу аймгийн ИТХ-аас шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд дараах хяналтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 08 тоот тогтоолоор улирал, сар бүр хийж байгаа хяналтын үр дүнг тооцох даалгаврыг аймгийн Засаг даргад үүрэг өгсөний дагуу "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд" хийсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт аудитын албаны хяналт шалгалтын үр дүнг хэлэлцэн тэмдэглэлээр үүрэг даалгавар өгч ажилласан байна.
2. Сумдын ИТХ-ын ажлын албанаас сумдын ЗДТГ-ын санхүүгийн алба, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчтэй хамтран ажиллах чиг үүргийн уялдаа холбоог сайжруулахаар сургалт зохион байгуулсан, мөн аймгийн санхүүгийн хяналт аудитын алба, аймгийн ИТХ-ын санхүү төсвийн хороотой хамтран 16 сумын 166 байгууллагад шалгалт хийж шилэн дансны мэдээллээ хуулийн хугацаанд тайлагнаагүй буюу илгээгээгүй, ажлын хэсгийн үнэлгээнд нөлөөлөх эрсдэл үүсч болзошгүй байсныг хяналт тавьж алдааг залруулснаас хэрэгжилт 99.4 хувьтай гэж дүгнэжээ.

В.2. Энэ онд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас 4 удаа хяналт хийж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.2-т "энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" гэсэн заалтын дагуу 2018 оны 2, 3 дугаар улиралд батлагдсан төсвийг хугацаандаа байршуулаагүй, төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан үзүүлэлтийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, сар, улирлын мэдээг хугацаанд нь мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ тус бүрээр дутуу мэдээлсэн нь нийт 14104 мэдээллээс 77 мэдээллийг огт мэдээлээгүй гэсэн зөрчлийг илрүүлсэн байна. Энэ онд хяналтыг 4 удаа зохион байгуулж санхүүгийн хяналт аудитын алба сар, улирал бүр шилэн дансны хяналтыг хийж

мөн сумдын төсвийн ерөнхийлөн захирагч нараас хяналт хийсэн ажлын тайлан, илтгэх хуудсыг авч ажилласан байна.

В.3. Төсвийн төвлөрүүлэн захирагч нарын үр дүнгийн гэрээнд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар заалт тусгаж өгсөн баяна.

Шилэн дансны тухай хуулийн 8.4-д “Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийн гол үзүүлэлт болгоно” гэж заасныг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч нартай үр дүнгийн гэрээ байгуулахдаа гэрээнд Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар заалт тусган хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

В.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж 75 хувийн биелэлттэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг дтуу мэдээлсэн мэдээллийг нөхөн байршуулан, бүрэн мэдээллэх арга хэмжээ авах гэж зөвлөсний дагуу 191 байгууллагын 11 төрийн 194 мэдээллийг нөхөж байршуулсан байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээ хэрэгжүүлсэн аж ахуй нэгж байгууллага тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг журмын дагуу байршуулах арга хэмжээ авах гэсний дагуу 10.0 сая төгрөгөөс дээш санхүүжилт авсан аж ахуй нэгжүүдийн мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.2 дахь заалтын дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ хуулийн 5.1, 5.7 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад тавих хяналтыг сайжруулах гэсний дагуу 276 байгууллагад цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээллээ байршуулж байх талаар заавар зөвлөгөө өгч ажилласан боловч цахим хуудсанд байршуулсан мэдээлэл хангалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.4-дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах гэсний дагуу төсөв захирагч нарын үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар заалт тусган хэрэгжүүлэн ажиллаж байгааг шалгаж үзээд өмөнх аудитаар өгсөн зөвлөмжийг 75 хувь биелүүлсэн гэж дүгнэж байна.

Аймаг дахь Төрийн
аудитын газар

Дүгнэлт, зөвлөмж

Нийцлийн аудитаар 4469.6 сая төгрөгийн мэдээлэл нөхөн байршуулах хугацаатай 76 албан шаардлага, хариуцлага тооцуулах 17 санал хүргүүллээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа ч зарим мэдээллийг хугацаа хоцроох болон огт мэдээлээгүй,
2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар хуулийн 6.1-д заасны дагуу тогтсон хугацаанд байршуулах мэдээллийг 88.3, 6.4 дэх хэсэгт заасан мэдээллийг 82.3 хувьтай мэдээлсэн,
3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээ хэрэгжүүлсэн аж ахуй нэгж байгууллага тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг журмын дагуу байршуулаагүй,
4. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуй нэгжүүд мэдээллээ мэдээлдэггүй, цахим хуудсанд цэс байхгүй,
5. Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлснээр байгууллагууд мэдээллээ харьцангуй оруулж хэвшсэн ч зарим босоо тогтолцоотой яам, агентлагийн харьяа байгууллагуудын цахим хуудас яам, агентлаг, өмчийн хэлбэр, аймаг зэргийн хаана нь харьяалагддаг нь тодорхой бус, иргэдэд шууд ойлгомжгүй,
6. Иргэд олон нийт сайтыг хэрэглэх, мэдээлэл авах талаар мэдлэггүй, сайтруу үзэхэд хүндрэлтэй, сар бүрийн мэдээллийг үзэхэд нэг бүрчилэн орж цаг хугацаа их зарцуулдаг,
7. Байгууллагууд цахим хуудаст мэдээлсэн гэж тэмдэглэдэг боловч нээж үзэхэд байх ёстой мэдээлэл байдаггүй,
8. Мэдээллийг бүрэн оруулаагүй, сар, улирал дамжин хийгдэж байгаа худалдан авалт, хөрөнгө оруулалтын мэдээллийг сарын гүйцэтгэл, өссөн дүнгээр янз бүрээр байршуулсан, давхардуулж байршуулсан зэрэг нэгдсэн ойлголтгүй, ойлгомжгүй зүйлээд байгаа,
9. Төрийн өмчит компаниуд өөрийн үйл ажиллагааны мэдээллээ оруулж байгаа ч улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бусад байгууллагад тендерт шалгарч болон гэрээгээр хийж байгаа ажил, хөрөнгө оруулалтын мэдээллийг байршуулахдаа дахин цэс нээлгэхээр байгаа,
10. Эмийн эргэлтийн сангуудын заримыг төрийн өмчит үйлдвэрийн газар, заримыг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэж цахимд оруулсан,
11. Хуулийн хэрэгжилтэнд жил бүр аудит, дотоодын хяналт шалгалт хийгдэж байгаа ч өмнөх аудитаас зөрчил 4.5 хувиар өссөн, томоохон хөрөнгө оруулалт, тендер шалгаруулалт, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг төдийлөн ил тод харж болохооргүй байгаа зэрэг нэг мөр болгож шийдвэрлэхээр асуудал, зөрчил байгаа тул шилэн дансны тухай хууль, цахим хуудсыг энгийн ойлгомжтой болгож шинэчлэх, мэдээлэл байршуулалтыг илүү ойлгомжтой, ил тод болгох, сайтыг шинэчлэх шаардлага байна гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА З.БАТЗОРИГ ТАНАА

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан дутуу мэдээлсэн мэдээллийг нөхөн байршуулан, бүрэн мэдээллэх арга хэмжээ авах.
2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээ хэрэгжүүлсэн аж ахуй нэгж байгууллага тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг журмын дагуу байршуулах арга хэмжээ авах.
3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийн мэдээллийг нөхөж байршуулах.
4. Шилэн дансны тухай хуулийн 8.2 дахь заалтын дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ хуулийн 5.1, 5.7 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад тавих хяналтыг сайжруулан ажиллахыг зөвлөж байна.

САНАЛ:

1. Иргэд олон нийт сайтыг хэрэглэх, мэдээлэл авах талаар мэдлэггүй, үзэхэд хүндрэлтэй, сар бүрийн мэдээллийг үзэхэд нэг бүрчилэн орж цаг хугацаа их зарцуулдаг, мэдээллийг төдийлөн ил тод харж болохооргүй байгаа тул цахим хуудсыг энгийн ойлгомжтой болгож шинэчлэх.

Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилган, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2019 оны 03 дугаар сарын 01-ний дотор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Г.НАМЧИНСҮРЭН

АУДИТОР

Х.БАТТУЛГА



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 30-ны өдөр

Дугаар 126

Булган

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дахь заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалт, 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9.2 дахь заалт, 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 7.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторын А/125 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг зөвшөөрсүгэй.
2. Аудитаар тогтоосон албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, биелэлтийг тооцон хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/, Ахлах аудитор /Г.Намчинсүрэн/-д даалгасугай.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

УАГ-НАГ/2018/01-НА

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА З.БАТЗОРИГ ТАНАА

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан дутуу мэдээлсэн мэдээллийг нөхөн байршуулан, бүрэн мэдээллэх арга хэмжээ авах.
2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээ хэрэгжүүлсэн аж ахуй нэгж байгууллага тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг журмын дагуу байршуулах арга хэмжээ авах.
3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийн мэдээллийг нөхөж байршуулах.
4. Шилэн дансны тухай хуулийн 8.2 дахь заалтын дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ хуулийн 5.1, 5.7 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад тавих хяналтыг сайжруулан ажиллахыг зөвлөж байна.

САНАЛ:

1. Иргэд олон нийт сайтыг хэрэглэх, мэдээлэл авах талаар мэдлэггүй, үзэхэд хүндрэлтэй, сар бүрийн мэдээллийг үзэхэд нэг бүрчилэн орж цаг хугацаа их зарцуулдаг, мэдээллийг төдийлөн ил тод харж болохооргүй байгаа тул цахим хуудсыг энгийн ойлгомжтой болгож шинэчлэх.

Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилган, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2019 оны 03 дугаар сарын 01-ний дотор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]*
АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР *[Signature]*

Г.НАМЧИНСҮРЭН
Х.БАТТУЛГА

БУЛГАН АЙМГИЙН "ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ"-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТӨЛБӨР ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

2018.
11.30

Д/д	Байгууллагын нэр	Албан тушаал	Хариуцах эзэн	Акт, албан шаардлагын дугаар	Төлбөр зөрчлийн товч утга	Төлбөр, зөрчлийн нийт дүн	Үүнээс		
							Акт	Албан шаардлага	Барагдуулсан Төлбөр
1	Баяннуур Соёлын төв	Дарга, нягтлан бодогч	М.Жүгдэрсүрэн 99602807 Т.Ганчимэг 99854100	ҮАГ-НАГ-2018/01-НА65/119	Шилэн дансны тухай хуулийн 6.1.3 дараа жилийн төсөв, 6.1.4. Санхүүгийн тайлан /хагас жил/, 6.1.5. ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт заалтын дагуу цахим хуудсанд мэдээлээгүй.	0	-		
2	Бугат Соёлын төв	Дарга, нягтлан бодогч	И.Пүрэвбат 99155926 Р.Хишигбаяр 94012959	ҮАГ-НАГ-2018/01-НА64/118	Шилэн дансны тухай хуулийн 6.1.3 дахь заалтын дагуу дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд мэдээлээгүй.	0	-		
3	Бүрэгхангай Соёлын төв	Дарга, нягтлан бодогч	Д.Бат-Өлзий 99442809 Б.Батцэцэг 99980178	ҮАГ-НАГ-2018/01-НА63/117	Шилэн дансны тухай хуулийн 6.1.3 дахь заалтын дагуу дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд мэдээлээгүй.	0	-		
4	Дашинчилэн Соёлын төв	Дарга, нягтлан бодогч	Н.Мөнхдулам 99984240 Р.Билгүүнзаяа 99313147	ҮАГ-НАГ-2018/01-НА58/112	Шилэн дансны тухай хуулийн 6.1.3 дахь заалтын дагуу дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд мэдээлээгүй.	0	-		
5	Сэлэнгэ сумын Соёлын төв	Дарга, нягтлан бодогч	П.Хонгорзул 99804943 Ц.Энхбат 99565388	ҮАГ-НАГ-2018/01-НА60/114	Шилэн дансны тухай хуулийн 6.1.3 дахь заалтын дагуу дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд мэдээлээгүй.	0	-		
6	Бүрэгхангай ИТХ	Дарга, нягтлан бодогч	С.Загас 99957652 Б.Энхцэцэг 99503302	ҮАГ-НАГ-2018/01-НА66/120	Шилэн дансны тухай хуулийн 6.1.4 дэх заалтын дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээлээгүй.	0	-		

7	Дашинчилэн ИТХ	Дарга, нягтлан бодогч	З.Ариунбуян 99790266 Г.Оюундарь 86089891	ҮАГ-НАГ-2018/01-НА62/116	Шилэн дансны тухай хуулийн 6.1.3 дахь заалтын дагуу дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд мэдээлээгүй.	0	-			
8	Сэлэнгэ сумын ИТХ	Дарга, нягтлан бодогч	м.Нямжаргал 99973311 П.Бэрцэцэг 99074199	ҮАГ-НАГ-2018/01-НА61/115	Шилэн дансны тухай хуулийн 6.1.3 дараа жилийн төсөв , 6.1.4. Санхүүгийн тайлан /хагас жил/ заалтын дагуу цахим хуудсанд мэдээлээгүй.	0	-			
9	Тэшиг сумын ИТХ	Дарга, нягтлан бодогч	Д.Туул 95359338 Г.Мөнхтулга 94309460	ҮАГ-НАГ-2018/01-НА59/113	Шилэн дансны тухай хуулийн 6.1.4 дэх заалтын дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээлээгүй.	0	-			
10	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Дарга, Нягтлан бодогчид	Н.Батжаргал, О.Баярчимэг,	ҮАГ-НАГ-2018/01-НА72/126	Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу 5 удаагийн 1.023 сая төгрөгийн шийдвэрийг цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээллээгүй.	1023000	1,023,000			
					Шилэн дансны тухай хуулийн 6.1.6-д заасны дагуу Төсвийн хэмнэлт хэтрэлтийн шалтгааныг мэдээлээгүй,	0				
11	Хануй голын сав газрын захиргаа	Дарга, Нягтлан бодогч	Д.Батболд Г.Оюунтуяа	ҮАГ-НАГ-2018/01-НА73/127	Шилэн дансны тухай хуулийн 6.1.4 дэх заалтын дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээлээгүй.	0				
					Шилэн дансны тухай хуулийн 6.1.3 дахь заалтын дагуу дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд мэдээлээгүй.	0				
					Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу 4 удаагийн шийдвэрийг цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээллээгүй.	1727138	1,727,138			
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	Дарга , Нягтлан бодогч	Д.Төгсбаяр, Б.Энхбаяр	ҮАГ-НАГ-2018/01-НА74/128	Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 - д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахдаа холбоотой 13 удаагийн тушаал шийдвэрийг цахим хуудсанд мэдээллээгүй.	4351911	4,351,911			

13	Байгаль орчны алба	Дарга , Нягтлан бодогч	Гантөмөр, Б.Будцэцэг	ҮАГ-НАГ- 2018/01- НА75/129	Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 - д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахдаа холбоотой 2 удаагийн тушаал шийдвэрийг цахим хуудсанд мэдээллээгүй.	1297805		1,297,805		
14	Статистикийн хэлтэс	Дарга , Нягтлан бодогч	Б.Мөнхбат, Ж.Чинчулуун	ҮАГ-НАГ- 2018/01- НА76/130	Шилэн дансны тухай хуулийн 6.1.4 дэх заалтын дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээллээгүй.	0				
